

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ
ЧИГЛЭЛЭЭР 2019-2020 ОНД ХЭРЭГЖСЭН
ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ӨВА-2021/15/-14-ШТА-ГА

Арвайхээр хот
2021 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга бөгөөд Тэргүүлэх аудитор О.Батжаргал
Утас: 70323253, цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер Д.Гансүх, Утас: 70323833,
цахим хаяг: Gansukhd@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Хорлоосүрэн, Утас: 70323108,
цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn

Аудитор: Э.Энхбаяр, Утас: 70323108,
цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn

Ө.Ринчинмядаг, Утас: 70323108,
цахим хаяг: RinchinmyadaqaU@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	2
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	2
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
БҮЛЭГ-1 ХЭДС-ийн үйл ажиллагааны орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт хангалтгүй байна. .5	
1.1. Сангийн эх үүсвэрийг хууль, тогтоомжтой уялдуулан оновчтой төлөвлөөгүй байна. .5	
1.2. Сангийн орлогыг хуулийн дагуу бүрэн бүрдүүлээгүй, төрийн байгууллагуудтай хамтран ажиллаагүй байна.	6
БҮЛЭГ-2 Аймгийн ХЭДС-гийн зарим хөрөнгө хууль, журмын дагуу зарцуулагдаагүй, төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт тодорхой үр дүнд хүрээгүй, төндөр шалгаруулалт хуулийн дагуу явагдаагүй байна.	9
2.1. Аймгийн ХЭДС-ийн хөрөнгийг хууль, журмын дагуу олгосон боловч зарим хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	9
2.2. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа ч зарим хөтөлбөр тодорхой үр дүнд хүрээгүй байна.	16
2.3. Төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.	22
БҮЛЭГ-3 Сангийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй, хяналтыг хэрэгжүүлж ажиллахгүй байна.	23
3.1. Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавьсан дотоод хяналт хангалтгүй байна.	23
3.2. Төсөл хөтөлбөрүүдийн тайлан мэдээ нь зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.	24
3.3. Сангийн үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналт үр дүнгээ өгөөгүй байна.	25
ДҮГНЭЛТ:	26
ЗӨВЛӨМЖ:	26
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:	Error! Bookmark not defined.



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ГА	Гүйцэтгэлийн аудит
ЗД	Засаг дарга
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
ӨВА	Өвөрхангай аймаг
ТББ	Төрийн бус байгууллага
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ШТА	Шууд төлөвлөгөөт аудит

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График-1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн гүйцэтгэл /сая.төгрөг/
График-2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны төсвийн хуваарьт орсон өөрчлөлт /сая.төгрөг/
График-3	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны төсвийн хуваарьт орсон өөрчлөлт /сая.төгрөг/

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт-1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019-2020 оны орлого зарлагын төсвийн гүйцэтгэл
Хүснэгт-2	ХЭДС-д хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүйн төлбөрөөс олсон орлогыг сүүлийн 3 жилийн байдлаар үзүүлбэл
Хүснэгт-3	ХЭДС-ийн авлага, өглөгийн үзүүлэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар /сая.төгрөг/
Хүснэгт-4-7	ХЭДС-ийн төсөл, хөтөлбөрүүдийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг 2 оноор харьцуулахад /сая.төгрөг/
Хүснэгт-8	ХЭДС-аас хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрөөс олгосон зээлийн эргэн төлөлтийн хэтрэлтийн хэмжээ болон зээл эргэн төлөлт хэтрүүлсэн иргэдийн тоо 2019, 2020 оны байдлаар /сая.төгрөг/
Хүснэгт-9	2019, 2020 онуудын төлөвлөгөө гүйцэтгэл хөтөлбөр, арга хэмжээгээр /сая.төгрөг/



НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторт аймаг дахь Төрийн аудитын газраас 2021 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу аймгийн ИТХ-ын захиалгыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын баталсан ӨВА-2021/15/-14-ШТА-ГА төлөвлөгөөг үндэслэн аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 2019-2020 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 2019-2020 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг аймгийн ИТХ-д болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Үүнд:

- ✚ ХЭДС-гийн орлогыг хууль, журамд зааснаар бодитой төлөвлөж, бүрдүүлсэн эсэх;
- ✚ ХЭДС-гийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан журмын дагуу зарцуулсан эсэх;
- ✚ ХЭДС-гийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Аудитыг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын ажлын баримтад тулгуурлан 2019-2020 оны ХЭДС-д улс, орон нутгийн төсвөөс хуваарилж олгосон шилжүүлэг, бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаар тэдний гүйцэтгэсэн ажлын тайлан, мэдээ, судалгаа, анхан шатны болон НББ-ийн баримт, бусад холбогдох материалд тулгуурлан гүйцэтгэв.

Аудитад хэрэглэсэн арга зүй:

Аудитыг АДБОУС 100, 400, 4100, Монгол улсын Төрийн аудитын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “ТАБ-аас аудит хийх журам” болон нийцлийн аудитын арга зүйг баримтлан шалгадагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашигласан болно.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- ✚ Төсвийн тухай хууль;
- ✚ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль



- ✚ Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолыг 1-р хавсралтаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”
- ✚ Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолыг 2-р хавсралтаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох журам”
- ✚ Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүд батлах тухай”
- ✚ “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Хөдөлмөрийн сайдын 2019 оны а/82 тоот тушаал
- ✚ “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх удирдамж батлах тухай” Хөдөлмөрийн сайдын 2019 оны а/83 тоот тушаал
- ✚ Аймгийн ИТХ, ЗД-аас гаргасан шийдвэр, бусад холбогдох дүрэм, журам.

Аудитын стандартын талаарх мэдэгдэл:

Энэхүү аудитыг аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын баталсан аудитын ӨВА-2021/15/-14-ШТА-ГА төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдөж ажиллав. Монгол улсын Төрийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “ТАБ-аас аудит хийх журам” болон нийцлийн аудитын арга зүйн дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох, нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитын явцыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал хянан удирдаж, аудитын менежер Д.Гансүх аудитын стандарт, арга зүйн дагуу хяналт тавьж, ахлах аудитор П.Хорлоосүрэн, аудитор Ө.Ринчинмядаг, Э.Энхбаяр нар 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл:

ХЭДС-гийн үйл ажиллагааны зохицуулалттай холбоотойгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг 2011 онд шинэчлэн найруулж, 2012, 2014, 2015, 2016, 2017 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын зохион байгуулалт нь Хөдөлмөрийн тухай хуулийн 137 дугаар зүйлд заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллага хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн талаарх төрийн бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага байна.

Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн алба нь улсын төсвөөс санхүүжиж ирсэн.

Сангийн зорилго нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, түүний төрөл, хэлбэр, хамрах хүрээ, санхүүжилт, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж заасны дагуу үйл ажиллагаа явуулж ирсэн байна. Үүнд:

Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 1 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар: “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний



ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг нэмэлт өөрчлөлтөөр оруулж, 2019-2020 онд хэрэгжүүлэхээр шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллажээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 03 дугаар сарын 05-ны А/83 дугаар тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг 2019-2020 онд хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж баталж үйл ажиллагаандаа мөрдсөн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 03 дугаар сарын 05-ны А/82 тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын дээд хэмжээг шинэчлэн тогтоож мөрдөж ажилласан байна.

Аудитаар 577.5 сая төгрөгийн үр өгөөж тооцож, 8 зөвлөмж, 594.3 сая төгрөгийн албан шаардлагыг аймгийн ХХҮГ-т хүргүүлж байна.

Өвөрхангай аймгийн ХЭДС-ийн 2019-2020 оны орлогын бүрдүүлэлт, зарим хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна.

БҮЛЭГ-1

ХЭДС-ийн үйл ажиллагааны орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт хангалтгүй байна.

1.1. Сангийн эх үүсвэрийг хууль, тогтоомжтой уялдуулан оновчтой төлөвлөөгүй байна.¹

Өвөрхангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн төсөөллийг 2019 онд 6 хөтөлбөр 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,697.9 сая төгрөг, 2020 оны төсвийн төсөлд 6 хөтөлбөр 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,717.5 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сангийн төсвөөс, ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг 10.0 сая төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 524.2 сая төгрөг тус тус орохоор төсвийн санал хүргүүлсэн байна. Монгол улсын ЗГ-ын 2009 оны 01 дүгээр сарын 28-ны 26 тоот тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээ”-г аймгуудад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 30 хувиар сар бүр төлөхөөр тогтоосон байна.

Аймгийн ХЭДС-гийн эх үүсвэрийг төлөвлөхдөө орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилаагүй, хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийн орлогыг бүрэн тусгаж төлөвлөөгүй байна.

Тиймээс ХЭДС-гийн орлогыг бүрэн төлөвлөх, төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах шаардлага байна.

¹ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

22.1.1.улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;

22.1.2.орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;

22.1.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү;

22.1.4.гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр;

22.1.5.гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл;

22.1.6.гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламж;

22.1.7.хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр;

22.1.8.бусад эх үүсвэр.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд сангийн эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө байхаар заасан ч орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилдаггүй байна. /ХЭДСангийн журамд: "Дэд санд аймаг, нийслэл, дүүргийн төсвөөс жил бүр олгох хөрөнгийн хэмжээ нь тухайн төсвийн орлогын 0.3 хувиас доошгүй байна" гэж заасан байдаг/

2019-2020 онд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нийт 6 төсөл арга хэмжээнд 7256 хүнийг хамруулж 3,403.2 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 9135 хүнд 2,891.9 сая төгрөгийн санхүүжилт олгож төсөвлөсөн зардлаас 512.0 сая төгрөгийг хэмнэсэн тооцоо гарч байгаа боловч төсөлд хамрагдсан хүний тоо 1879 хүнээр илүү байна. Энэ нь үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт хийх шаардлагатайг харуулж байна.

1.2. Сангийн орлогыг хуулийн дагуу бүрэн бүрдүүлээгүй, төрийн байгууллагуудтай хамтран ажиллаагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн удирдамжийг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нэгдсэн төсвийг, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын тушаалаар аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн төсвийн хуваарийг баталж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор 2019, 2020 онд хэрэгжүүлэхээр нийт 6 хөтөлбөр батлан хэрэгжсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2019-2020 онд нийт 3,403.2 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 3,037.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019-2020 оны орлого зарлагын төсвийн гүйцэтгэл

Хүснэгт-1

Он	Орлого			Зарлага		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
2019	2,174.9	2,114.8	97.2%	2,174.9	1,996.2	91.7%
2020	1,228.3	923.0	75.1%	1,228.3	895.7	72.9%
Нийт	3,403.2	3,037.8	89.3%	3,403.2	2891.9	84.9%

Дээрх хүснэгтээс харахад аймгийн ХЭДС-гийн орлого 10.7 хувиар дутуу бүрдсэн, зарлагыг 15.1 хувиар дутуу санхүүжүүлж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв санд төвлөрүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 24.5-т "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн батлагдсан төсвийг аймаг, нийслэл, дүүрэгт хуваарилахдаа хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хамрагдах хүний тоо зэргийг үндэслэнэ." гэж заасны дагуу аймгийн ХХҮГ-аас төсвийн төсөл хүргүүлсэн боловч Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамнаас харъяа байгууллагуудын төсвийг хянаж батлахдаа байгууллагын санал болгосон төсвийн төсөл, төсөл арга хэмжээний зардлуудыг зориулалтын дагуу нарийвчилж баталдаггүй, төсвийн тодотголыг жилийн эцсээр буюу 12 сард төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж баталж байгаа нь хөтөлбөрийн санхүүжилт дутуу орох, оройтох, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнгүй болох, төрийн сангийн гүйлгээ хаагдахтай холбоотой гүйлгээ гаргахдаа алдаа, зөрчил гаргах зэрэг эрсдэл үүсч 2020 онд хэрэгжих Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн санхүүжилттэй холбоотой өр үүссэн байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 111 дугаар тогтоолоор аж ахуйн нэгж, байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах бөгөөд ажиллуулаагүй бол орон тоо тутамд сар бүр төлбөр төлөх тухай заасан байна. Аймгийн ХХҮГ-ын судалгаагаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж



байгаа 25-аас дээш орон тооны ажилтантай 51 байгууллага, 50-иас дээш орон тооны ажилтантай 47 байгууллага нийт 98 аж ахуйн нэгж, байгууллагын судалгаа гаргасан байна. **ХЭДС-д хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүйн төлбөрөөс олсон орлогыг сүүлийн 3 жилийн байдлаар үзүүлбэл**

Хүснэгт-2

Үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он
ААНБ-ийн тоо	97	98	97
Ажиллавал зохих ХБИ-ний тоо	200	204	202
Ажиллаж буй ХБИ-ний тоо	124	152	150
ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого /сая.төг/	Төлбөл зохих мөнгөн дүн	86.3	35.1
	Төлбөр төлсөн мөнгөн дүн	Төлөв Гүйц	Төлөв Гүйц
		- 1.2	1.5 14.4
			10.0 32.5

Дээрх хүснэгтээс үзэхэд Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүй төлбөрийн орлогын төлөвлөгөө 30.7 хувиар давуулан биелүүлсэн ч төлөвлөлт үндэслэлгүй байна.

ХЭДС-д Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй 73 байгууллага, 28 аж ахуйн нэгж байдгаас 2019, 2020 онд нийт 9 байгууллага, 2 аж ахуйн нэгжээс 63.0 сая төгрөгийн төлбөр орохоос 2019, 2020 онуудад 2018 онд орох байсан 15 байгууллагын 35.5 сая төгрөг 2019 онд орох байсан 3 байгууллагын 11.4 сая төгрөг нийт 46.9 сая төгрөгийг оруулж төвлөрүүлсэн боловч 6 байгууллага, 2 аж ахуйн нэгжийн 51.6 сая төгрөгийг ХЭДС-д төвлөрүүлээгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүйн төлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд дараах хүндрэл үүсдэг байна. Үүнд:

- ✚ Ажил олгогчид Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтыг хэрэгжүүлдэггүй
- ✚ Ажилчдын дундаж цалинг үнэн зөв мэдээлдэггүй
- ✚ Ажилчдын орон тоог буруу мэдээлдэг
- ✚ Төрийн хяналт, шалгалтын байгууллага болон төрийн байгууллагуудын уялдаа холбоо байхгүй зэрэг шалтгаанаас орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт бодитой бус байна.


Аймгийн ХЭДС-д 2019 оны төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөр 2 арга хэмжээг ХХҮЕГ-ын даргын 2019 оны а/14 тоот тушаалаар улсын төсвөөс 1,618.1 сая төгрөг санхүүжүүлэх төсвийн хуваарь батлагдсан боловч тайлант онд ХХҮЕГ-ын даргын а/117, а/161, а/200, а/260 тоот тушаалуудаар 4 удаа өөрчлөлт орж 2,174.9 сая төгрөгийг зарцуулахаар батлагдан улсын төсвөөс 2,114.8 сая төгрөгийн санхүүжилт авч 1,996.2 сая төгрөг зарцуулсан байна. Мөн тайлант онд ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлогоос 1.5 сая төгрөг орохоор төлөвлөгдсөн боловч гүйцэтгэлээр 14.4 сая төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөөс 485.4 сая төгрөгийг санд төвлөрүүлсэн байна.

Харин аймгийн ХЭДС-гийн 2020 оны гүйцэтгэлээс харахад 6 хөтөлбөр 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,483.1 сая төгрөг, гадаад улс, олон улсын байгууллагын зээл тусламжын орлогоос 843.8 сая төгрөг батлагдсан боловч ХХҮЕГ-ын даргын а/114, а/126, а/166, а/174, а/186 тоот тушаалуудаар 5 удаа төсвийн хуваарьт өөрчлөлт орсон байна. 1,228.3 сая төгрөг батлагдан улсын төсвөөс 923.0 сая төгрөгийн санхүүжилт авч 895.7 сая төгрөг зарцуулсан байна. Тайлант онд ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлогоос 10.0 сая төгрөг орохоор төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 32.5 сая төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөөс 388.9 сая төгрөгийг санд төвлөрүүлсэн байна.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн гүйцэтгэл /сая.төгрөг/

График-1



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны төсвийн хуваарьт орсон өөрчлөлт /сая.төгрөг/


График-2



Төсөв батлуулах, тодотгол хийхдээ эдийн засгийн шинжилгээ судалгаа хийдэггүй, өмнөх жилүүдэд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэл үр дүнг тооцоогүй, жил бүр төсвийн хуваарьт олон удаа өөрчлөлт оруулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны төсвийн хуваарьт орсон өөрчлөлт /сая.төгрөг/

График-3





ХЭДС-ийн авлага, өглөгийн үзүүлэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар /сая.төгрөг/ Хүснэгт-3

Үзүүлэлт	2019 он		2020 он	
	Авлага	Өглөг	Авлага	Өглөг
Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөр	736.8	-	1041.5	17.5
Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	6.5	-	3.4	
Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	330.3	-	301.8	90.0
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	607.7	-	466.5	
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	141.3	-	162.0	3.8
Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	39.6	-	53.6	
Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл	340.0	-	390.2	
Татаас, санхүүжилтийн авлага	14.7	-	3.5	
ДҮН	2,202.2	-	2,419.3	111.3

Дээрх хүснэгтээс харахад санхүүгийн тайлангаарх жилийн эцсийн авлага ихтэй байгаа төдий чинээ эргэн төлөлт муу байгааг харуулж байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн ИТХ-ын дарга О.Пүрэвдорж, Засаг дарга А.Ишдорж, Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга Т.Нарангараев нарт:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, журмын дагуу орон нутгийн төсвөөс аймгийн ХЭДС-д төсвийн орлогын 0.3 хувиас доошгүй хөрөнгийг хуваарилан төвлөрүүлж байх.
- Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийн орлогыг үндэслэлтэй бүрэн төлөвлөж, тухайн байгууллагуудтай хамтарч ажиллах.

БҮЛЭГ-2

Аймгийн ХЭДС-гийн зарим хөрөнгө хууль, журмын дагуу зарцуулагдаагүй, төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт тодорхой үр дүнд хүрээгүй, тендер шалгаруулалт хуулийн дагуу явагдаагүй байна.

2.1. Аймгийн ХЭДС-ийн хөрөнгийг хууль, журмын дагуу олгосон боловч зарим хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.²

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас 2019-2020 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд 8 хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн байна.

Уг хөтөлбөрийн хамрах хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор баталсан байна.

² Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн **6.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг дараах төсөл, хөтөлбөрийн хэлбэрээр хэрэгжүүлнэ:**

6.3.1.хөдөлмөрт бэлтгэх;
6.3.2.хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах;
6.3.3.малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих;
6.3.4.ажил олгогчийг дэмжих;
6.3.5.нийтийг хамарсан ажил зохион байгуулах;
6.3.6.ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;



ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН УР ЧАДВАР ОЛГОХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД:

Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээг 2019 онд Арвайхээр, Хужирт сумуудад “Хөгжлийн хөтөч” төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж 5.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан ажил хайгч, мэргэжилгүй болон мэргэжлээ өөрчлөх хүсэл сонирхолтой иргэдийг 4 төрлөөр /Хоол үйлдвэрлэлийн тогооч, талх, нарийн боов, хөнгөн үйлдвэрлэлийн оёдол эсгүүр, гоо сайхан/ зэрэг мэргэжил олгох сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 18.5 сая төгрөгийг зарцуулсан.

АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД:

2019 онд: Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хүрээнд 420.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт дараах төслүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1

Хөтөлбөрийн хүрээнд “Дэлгэрэх бүтээмж” сургалтын байгууллагатай хамтран 240 иргэнд “Төсөл бичих”, “Бизнесээ эхэл, хөгжүүл” сургалтыг зохион байгуулсан.

**6.3
сая**

2

Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 14 сумын 30 бүлэгт 120 иргэнийг хамруулж, үр бордооны болон газар хагалгаа, үрлэгээ зэрэгт дэмжлэг үзүүлэх болон хашааны тор, шон, ажлын багаж хэрэгслээр бүлгийн иргэдийг хангасан.

**32.9
сая**

3

Нийтийг хамарсан ажлаар түр ажлын байраар хангах арга хэмжээг аймгийн хэмжээний 19 сумын нийтийн эзэмшлийн зам талбайд тохижилт хийх, байгаль орчныг хамгаалах, цэвэрлэх, малын сэг зэм цэвэрлэх чиглэлээр зохион байгуулж 940 иргэнийг түр ажлын байраар хангасан.

**163.5
сая**

4

Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээний хүрээнд орон нутгийн ажилгүй иргэдийг бүлгийн зохион байгуулалтад оруулж, тохижилт үйлчилгээний чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө гаргаж, түр ажлын байраар хангаж ажиллан 10 сумын 50 иргэнийг хамруулсан.

**20.4
сая**

5

Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөд 21 иргэнд санхүүжилт олгосон байна.

**11.7
сая**

6

Ажил олгогчид олгох дэмжлэгт 12 иргэнийг хамруулж, санхүүжилт олгосон.

**38.3
сая**

2020 онд: Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 1326 иргэн хамрагдаж дараах төслүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1

Санхүүгийн дэмжлэгт 222 иргэнийг хамруулсан.

**458.0
сая**

2

Аж ахуй эрхлэлтийн сургалтад 159 иргэн хамруулсан.

**3.7
сая**

3



Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөд 21 иргэн хамрагдсан.	10.6 сая
4 Ажил олгогчийн дэмжлэгт 1 аж ахуйн нэгж хамрагдсан.	4.1 сая
5 Нийтийг хамарсан ажилд 772 иргэн хамрагдсан.	115.0 сая
6 Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээнд 26 иргэн хамрагдсан.	24.1 сая
7 Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 125 иргэн хамрагдсан.	28.9 сая

ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД:

2019 онд:

1 Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн “Start up” арга хэмжээг Бест метод ХХК-ны дэргэдэх “Бэст инноваци” бизнес хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулж, 34 бүлэг гарааны бизнесээ эхлүүлэх шинэлэг санааг танилцуулснаас хөдөө аж ахуй, газар тариалан, авто засвар, бетонон шал, токарийн цех, тахианы аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлийн 23 бүлгийн санааг дэмжин 10.0 сая төгрөгийн хүүгүй санхүүгийн дэмжлэгт хамрагдах эрхийн бичгийг олгож, хурдасгуур хөтөлбөрт хамруулан санхүүжилт олгосон.	220.0 сая
2 Аж ахуй эрхлэлтийн сургалтад 120 иргэнийг хамруулсан.	3.6 сая
3 Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газартай хамтран “Залуучууд ба хөдөлмөр эрхлэлт” зөвлөгөөний арга хэмжээг зохион байгуулж, 450 залуучуудыг оролцуулж Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж, дүрэм, журам, төсөл хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг өгч, ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны мэдээллийг сурталчилж, ажилд зуучлах үйлчилгээг үзүүлсэн.	

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрт давхардсан тоогоор нийт 118 иргэн хамрагдаж, нийт 223.6 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

2020 онд:

1 Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн гарааны бизнесийг хөгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд 1 иргэнийг хамруулж санхүүжилт олгосон.	9.0 сая
2 Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөд 1 иргэнийг хамруулж санхүүжилт олгосон.	10.2 сая



МАЛЧДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД:

2019 онд:

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн малжуулах арга хэмжээнд хамрагдах нөхцөл, шаардлагыг хангах хөдөлмөрийн чадвартай, 18-45 насны, бог малд шилжүүлснээр 200 хүртэл толгой малтай өрхийн судалгааг гаргаж, хөтөлбөрийн талаар олон нийтэд мэдээлэл хүргэсэн.

Тус хөтөлбөрт 18 сумын 69 өрхийн 138 залуу малчдыг хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 69 өрхөд 310.0 сая төгрөгийн 6217 толгой бог малаар малжуулсан байна.

Хөтөлбөрт хамрагдсан залуу малчдын уулзалт зөвлөгөөнийг Арвайхээр суманд зохион байгуулж, залуу малчдад мал маллагааны арга ажиллагаа болон аж ахуй эрхлэх сургалтыг Аймгийн Политехникийн коллежтой хамтран сургалт зохион байгуулсан. Сургалтаар Шинэ хөгжлийн түлхүүр ТББ-ын тэргүүн Н.Амаржаргал залуу малчдад “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдвээр лекц уншиж, залуу гэр бүлүүдэд тулгамддаг асуудал, харилцаа хандлагын талаар зөвлөгөө өгсөн. Дээрх арга хэмжээнд 18 сумын 90 малчин оролцож хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 7.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

2020 онд малжуулах хөтөлбөр хэрэгжээгүй байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД:

2019 онд:

1

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 50 хувийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 49 иргэний төслийг хүлээн авч 30 иргэний төслийг удирдамжийн дагуу сонгон шалгаруулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 30 иргэнд санхүүгийн дэмжлэг олгосон.

**65.0
сая**

2

Аж ахуй эрхлэлтийн сургалтад 105 иргэнийг хамруулсан.

**2.8
сая**

3

Хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг Өвөрхангай аймаг дахь Политехникийн коллежтой хамтран ажиллах гэрээ байгуулж, 19 иргэнийг хамруулсан.

**3.9
сая**

4

Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээг “Хөгжлийн хөтөч” төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй 26 иргэнийг хамруулсан.

**1.8
сая**

Хөгжлийн бэрхшээлтэй 6 иргэнийг байнгын ажлын байраар хангасан 4 байгууллагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн ажил олгогчийн урамшууллын гэрээ байгуулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 183 иргэн хамрагдаж, нийт 75.9 сая төгрөгийн санхүүжилт зарцуулсан байна.

2020 онд

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 56 иргэнд 87.2 сая төгрөг зарцуулсан байна.Үүнд:



1	Санхүүгийн дэмжлэгт 52 иргэнийг хамруулсан.	78.0 сая
2	Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөд 2 иргэнийг хамруулсан.	1.2 сая
3	Ажил олгогчийн урамшуулалд 2 аж ахуйн нэгжийг хамруулсан.	8.0 сая

АХМАД МЭРГЭЖИЛТНИЙ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД:

2019 онд:

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд ахмадын зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдах хүсэлтэй 31 байгууллагын 32 төслийг хүлээн авсан.

Арга хэмжээг хэрэгжүүлэн 16.5 сая төгрөг, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт 18 ахмадыг хамруулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 33.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг олгож нийт 49.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/166 тушаалын дагуу мэргэжлийн өндөр мэдлэг, туршлагатай ахмад мэргэжилтнүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэн ажлын байраар хангах зорилгоор аймгийн Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, ахмад мэргэжилтнүүдтэй хамтран 4 талт гэрээ байгуулж, "Хүүхэд хамгаалагч" туршилтыг төслийг 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлүүлж тухайн төслийн хүрээнд цагдаагийн байгууллагаас тэтгэвэрт гарсан 2 ахмад ажилтан ажлын байраар хангагдан ажиллаж байна.

2020 онд:

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 17 иргэнд 28.3 сая төгрөг зарцуулсан байна. Үүнд:

1	Санхүүгийн дэмжлэгт 15 иргэнийг хамруулсан.	27.0 сая
2	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 2 иргэн хамрагдсан.	1.3 сая

ОРОН НУТГИЙН ОНЦЛОГ ХЭРЭГЦЭЭНД НИЙЦҮҮЛСЭН ЗОРИЛТОТ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД

2019 онд:

Итгэлийн зээлд 44 иргэн хамрагдаж 2.0 -15.0 сая төгрөгийн хооронд нийт 340.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

2020 онд:

Итгэлийн зээлд 33 иргэн хамрагдаж 2.0-4.0 сая төгрөгийн хооронд 82.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.



ХЭДС-ийн төсөл, хөтөлбөрүүдийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг 2 оноор харьцуулахад /сая.төгрөг/

Хүснэгт-4

№	Үзүүлэлт	2019				2020				Харьцуулалт	
		Төл		Гүйц		Төл		Гүйц		Төл	Гүйц
		Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө		
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр	2400	19.2	2400	18.4	350	4.5	910	4.5	14.7	13.8
2	Ажилд зуучлах	1060	13.3	1060	13.3	372	2.6	850	2.6	10.7	10.7
3	Хөдөлмөрт бэлтгэх	125	5.6	125	5.6		0.0		0.0	5.6	5.6
4	Мэргэжлийн болон даван сургалт	81	18.6	109	18.5		0.0		0.0	18.6	18.5
5	Санхүүгийн дэмжлэг	84	420.0	147	420.0	120	598.0	222	458.0	178.0	-38.0
6	Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох	210	6.3	240	6.3	125	3.8	159	3.8	2.6	2.5
7	Борлуултын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт		21.6	21	11.7		23.0	21	10.6	-1.4	1.1
8	Ажил олгогчид олгох дэмжлэг	10	38.4	12	38.3	2	9.1	1	4.1	29.3	34.2
9	Нийтийг хамарсан ажил	634	177.6	940	163.5	411	115.0	772	115.0	62.6	48.5
10	Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээ	37	70.0	50	20.4	14	25.6	26	24.1	44.4	-3.7
11	Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах	75	37.5	120	32.9	58	29.0	125	29.0	8.5	4.0
12	Гарааны бизнесийг хөгжүүлэх арга хэмжээ зохион байгуулах		10.0		10.0	1	9.0	0	9.0	1.0	1.0
13	Гарааны бизнес эрхлэлтийг дэмжих	23	230.0	22	220.0	13	130.0	0	0.0	100.0	220.0

ХЭДС-ийн төсөл, хөтөлбөрүүдийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг 2 оноор харьцуулахад /сая.төгрөг/

Хүснэгт-5

№	Үзүүлэлт	2019				2020				Харьцуулалт	
		Төл		Гүйц		Төл		Гүйц		Төл	Гүйц
		Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө		
14	Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	120	3.6	120	3.6		0.0		0.0	3.6	3.6
15	Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт		21.6	10	4.6		2.0	1	1.2	19.6	3.4
16	Малчин өрхийг малжуулах	62	310.0	69	310.0		0.0		0.0	310.0	310.0



17	Гэрээт малчин өрхийн хөдөлмөр ЭДАрга хэмжээ	10	10.0	12	4.1	2	3.8	11	3.8	6.2	0.3
18	Мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт	280	35.0	90	34.8		0.0		0.0	35.0	34.8
19	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	26	1.8	26	1.8		0.0		0.0	1.8	1.8
20	Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ	5	2.1		0.0		0.0		0.0	2.1	0.0
21	Санхүүгийн дэмжлэг	13	65.0	30	65.0	18	87.5	52	78.0	-22.5	-13.0
22	Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт		13.4	3	2.4	0	2.8	2	1.2	10.6	1.2
23	Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	94	2.8	105	2.8		0.0		0.0	2.8	2.8
24	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	19	5.5	19	4.0		0.0		0.0	5.5	4.0
25	Ажил олгогчийн урамшуулал		0		0.0	2	8.0	2	8.0	-8.0	-8.0
26	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	24	20.2	37	16.5	2	1.7	2	1.3	18.5	15.2

ХЭДС-ийн төсөл, хөтөлбөрүүдийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг 2 оноор харьцуулахад /сая.төгрөг/

Хүснэгт-6

№	Үзүүлэлт	2019				2020				Харьцуулалт	
		Төл		Гүйц		Төл		Гүйц		Төл	Гүйц
		Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө		
27	Санхүүгийн дэмжлэг	11	33.0	18	33.0	10	31.0	15	27.0	2.0	6.0
28	Итгэлийн зээл		360.0	44	340.0	33	82.0	33	82.0	278.0	258.0
29	Хүүгийн хөнгөлөлт	16	5.8	1	0.8	3	2.3	3	2.3	3.5	-1.5
30	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл		4.0		4.0		3.0		1.6	1.0	2.4
31	Хөдөлмөрийн харилцаа хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилт		5.9		5.9		0.4		0.4	5.5	5.5
32	Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн сан		9.1		9.1		7.7		7.7	1.4	1.4
33	Хөдөлмөрийн салбарын ажилтнуудын чадавх бэхжүүлэх сургалт		6.1		6.1		6.7		6.7	-0.6	-0.6
34	Сурталчилгаа олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах		144.5		144.4		16.4		16.4	128.1	128.0
35	Төсөл хөтөлбөрийн хяналт үнэлгээ		12.0		9.0		15.0		8.6	-3.0	0.4



36	Гарын авлага, материал хэвлэх		11.0		11.0		3.6		3.6	7.4	7.4
37	Хүүхэд хамгаалагч төсөл	2	4.7	2	4.5	2	4.7	4	4.5	0.0	0.0

ХЭДС-ийн төсөл, хөтөлбөрүүдийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг 2 оноор харьцуулахад нийт дүн /сая.төг/ Хүснэгт-7

№	Үзүүлэлт	2019				2020				Харьцуулалт	
		Төл		Гүйц		Төл		Гүйц		Төл	Гүйц
		Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө		
	Нийт	5421	2155.4	5832	1996.2	1538	1228.3	3211	915.0	927.1	1081.2

Дээрх хүснэгтээс харахад 2020 оны төсөл хөтөлбөрийн төлөвлөгөө нь 2019 оноос 927.1 сая төгрөгөөр, санхүүжилт нь 1081.2 сая төгрөгөөр буурсан байна.

ХЭДС-ИЙН СУРТАЛЧИЛГАА ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛААС ДАРААХ ЗҮЙЛД ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛСАН БАЙНА. ҮҮНД:

- Хөтөлбөр төслийн хяналт үнэлгээний зардлаас хяналтаар явсан баримт материал мэдээ тайлан байхгүй шатахууны зардалд 2019 онд 8.2 сая төгрөг, 2020 онд 5.9 сая төгрөг.
- Туршлага судлах ажлаар аймгийн ХХҮГ-ын ажилчид нь 2020 онд Завхан, Архангай явах томилолтын зардалд 0.9 сая төгрөг, жолоочийн зардал 1.0 сая төгрөг, шатахууны зардалд 1.0 сая төгрөг нийт 2.9 сая төгрөг.
- Өвөрхангай аймгийн ахмадын хороо ТББ-ын 1000 ахмадын уулзалт хэлэлцүүлгийн зардалд 2019 онд 43.5 сая төгрөг.
- Төгрөг тэмээчдийн холбоо ТББ-ын малчид тэмээчдийн уулзалтын зардалд 3.5 сая төгрөг тус тус зарцуулсан байна.
- Жирэм технологи ХХК-нд EWork программын үнэ 8.4 сая төгрөг
Мөнхийн үсэг ХХК-нд сэтгүүлийн үнэнд 15.0 сая төгрөгийг нийт 87.4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2.2. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа ч зарим хөтөлбөр тодорхой үр дүнд хүрээгүй байна.³

ХЭДС-аас 2019 онд 5832 төсөл хөтөлбөр хэрэгжиж 1996.2 сая төгрөг, 2020 онд 3211 төсөл хөтөлбөр хэрэгжиж 923.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

³ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд:

10 дугаар зүйл.Хөдөлмөрт бэлтгэх

11 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах

12 дугаар зүйл.Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих

13 дугаар зүйл.Ажил олгогчийг дэмжих

14 дүгээр зүйл.Нийтийг хамарсан ажил зохион байгуулах

15 дугаар зүйл.Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих



Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь Аймгийн засаг даргаар ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан 2019, 2020 онд хийгдэх ажлын төлөвлөгөө баталж ажилласан байна. Орон нутгийн сонгуультай холбоотой удирдлагууд солигдсоноос хойш салбар зөвлөлөө 2021 оны 04 дүгээр сарын 12-ны А/181 тоот аймгийн Засаг даргын захирамжаар шинэчлэн байгуулсан байна.

Төсөл хөтөлбөр хэрэгжих бүрд аймгийн ХХҮГ-ын даргын тушаалаар хөтөлбөрийн эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний төслийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулан төслийн сонгон шалгаруулалтыг явуулж ирсэн байна.

Арвайхээр, Сант, Баянгол, Төгрөг, Гучин-Ус, Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Хайрхандулаан сумдад 2019-2020 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүнтэй танилцахад:

Арвайхээр сүм:

1. Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцсэн зорилтот төслийн хүрээнд 2019 онд 31 иргэнд 2.0-15.0 сая төгрөгийн хооронд 207.0 сая төгрөгийн зээл 2020 онд 31 иргэнд 2.0-4.0 сая төгрөгийн 76.0 сая төгрөгийн зээл.
2. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 186 иргэн хамрагдаж 375.0 сая төгрөг.
3. Бүлийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 66 иргэн 16 бүл хамрагдаж үйл ажиллагаагаа явуулсан байна.
4. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 1 иргэн хамрагдаж 5.0 сая төгрөг.
5. Ахмадын зөвлөх үйлчилгээнд 21 иргэн хамрагдаж 29.3 сая төгрөг.
6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 17 иргэн хамрагдаж 36.0 сая төгрөг.
7. Залуучуудын гарааны бизнес төсөлд 17 иргэн хамрагдаж 170.0 сая төгрөгийн зээлүүдийг тус тус олгосон байна.
8. Нийтийг хамарсан ажлаар мандлын цэцгийн үрсэлгээ бэлтгэх ажилд 6.7 сая төгрөг, сэг зэм устгах ажилд 2.4 сая төгрөг, мод тарих модны нүх ухах ажилд 5.6 сая төгрөг, дайргын голын цэвэрлэгээний ажилд 1.2 сая төгрөг, хогийн ургамал шарилж түүх ажилд 2.8 сая төгрөг нийт 18.7 сая төгрөг зарцуулсан байна.

Хайрхандулаан сүм:

1. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 6 иргэн хамрагдаж 26.0 сая төгрөг.
2. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 4 иргэн хамрагдаж 7.5 сая төгрөг.
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 6 иргэн хамрагдаж 7.0 сая төгрөг.
4. Ахмадын санхүүгийн дэмжлэгт 1 иргэн 2.0 сая төгрөг тус тус олгосон.
5. Бүлийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 8 иргэн 2 бүл хамрагдаж үйл ажиллагаагаа явуулсан байна.

Богд сүм:

1. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 8 иргэн хамрагдаж 35.0 сая төгрөг
2. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 5 иргэн хамрагдаж 12.0 сая төгрөг тус тус олгосон.

Гучин-Ус сүм:

1. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 4 иргэн хамрагдаж 17.0 сая төгрөг.
2. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 3 иргэн хамрагдаж 6.0 сая төгрөг.
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 4 иргэн хамрагдаж 5.5 сая төгрөг тус тус олгосон.

Баруунбаян-Улаан сүм:



1. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2 иргэн хамрагдаж 10.0 сая төгрөг.
2. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 3 иргэн хамрагдаж 9.5 сая төгрөг.
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 1 иргэн хамрагдаж 2.0 сая төгрөг тус тус олгосон байна.
4. Бүлийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 4 иргэн 1 бүл хамрагдаж үйл ажиллагаагаа явуулсан байна

Нарийнтээл сүм:

1. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 4 иргэн хамрагдаж 18.0 сая төгрөгийн санхүүжилт авсан
2. Бүлийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 8 иргэн 2 бүл хамрагдаж үйл ажиллагаагаа явуулсан байна.

Төгрөг сүм:

1. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2 иргэн хамрагдаж 9.0 сая төгрөг.
2. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 1 иргэн хамрагдаж 3.0 сая төгрөг тус тус олгосон байна.
3. Бүлийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 8 иргэн 2 бүл хамрагдаж үйл ажиллагаагаа явуулсан байна

Баянгол сүм:

1. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 3 иргэн хамрагдаж 13.0 сая төгрөг.
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 4 иргэн хамрагдаж 9.0 сая төгрөг тус тус олгосон байна.

Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн хүрээнд аймгийн хэмжээнд 2019 онд 44 иргэнийг хамруулж 340.0 сая төгрөг, 2020 онд 33 иргэнийг хамруулж 82.0 сая төгрөгийн итгэлийн зээлийг олгосон байна. Төслийн хэрэгжилтийн явц, үр дүн, зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг түүвэрлэн үзэж 25 иргэний үйл ажиллагаатай танилцлаа.

Аудитаар тулгалт хийхэд 21 иргэн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан боловч цар тахлын хорио цээртэй холбоотой орлого буурч хугацаа хэтэрсэн байна.

Зээлдэгч тус бүр төсөл хэрэгжүүлэх хамтран ажиллах гэрээ хийсэн боловч гэрээний заалтын 2.3-д “Төслийн хэрэгжилтийн явц, үр дүн, санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, хавсралтад тусгасан Б талын боловсруулсан эргэн төлөлтийн хуваарийн биелэлтэд хяналт тавьж ажиллана.”, 3.5-д “Төслийн үйл ажиллагааны тайланг жил бүр тогтоосон хугацаанд гаргах /санхүүгийн баримт хавсаргах/ ба төслийн үйл ажиллагаа дуусахад нэгдсэн тайланг гаргаж ирүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлж хяналт тавьж ажиллаагүй байна.




Зориулалтын дагуу хэрэгжиж буй төслүүдийн зургаас харуулбал:

Зээлдэгч Т.Одончимэг нь 2019 оны 11 сард шүдний эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах зориулалтаар 36 сарын хугацаатай 11 сая төгрөгийн зээл авсан. Газар дээрх хяналтаар шалгахад зээлийг зориулалтын дагуу ашиглаж үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байсан боловч ковид-19 цар тахалын улмаас бизнесийн орлого ашиг буурсан байна.



Зээлдэгч Ч.Сарантуяа нь Арвайхээр сумын 3 дугаар багт хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай цэвэр бохир ус, дулааны шугамд холбох ажилд зориулж 10 сая төгрөгийн зээл авсан. Газар дээрх хяналтыг хэрэгжүүлэхэд зээлийг зориулалтын дагуу ашиглаж үйл ажиллагаа хэвийн явуулахад бэлэн болсон ч ковид-19 цар тахалын улмаас бизнесийн үйл ажиллагаа зогсож хугацаа хэтрэх шалтгаан болсон байна.



Зээлдэгч Д.Гантулга нь Арвайхээр сумын 4 дүгээр багт халуун ус ажиллуулахад шаардлагатай дотор заслын материал авахад зориулж 5 сая төгрөгийн зээл авч зориулалтын дагуу зарцуулсан боловч ковид-19 цар тахалтай холбоотой үйл ажиллагаа нь зогсож ашиг орлогогүй болж зээлийн хугацаа хэтэрсэн байна.





Зээлдэгч Ж.Батнасан 2019 онд арьс шир боловсруулж суран эдлэл хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах зориулалтаар 4 сая төгрөг авч үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. Зээлдэгчийн бүтээгдэхүүн орон нутгийн иргэдэд танигдаж захиалга авч захиалгын дагуу хийж борлуулж байна. Жишээ нь: Хөхүүр гэхэд багтаамжаасаа шалгаалан 150,000-1,500,000 төгрөгөөр, Эмээл, хазаар, ногт, чөдөр зэргийг сувенир хэлбэрээр 40,000 төгрөг, хонины нэхийг үйлдвэрийн аргаар элдэж хөнжил, гудас зэргийг 200,000-250,000 төгрөгөөр захиалгаар хийж байна.



Зээлдэгч Г.Амирдаабазар нь 2019 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд гэрийн мод эрээлэх чиглэлээр тоног төхөөрөмж авах зориулалтаар 3 сая төгрөгийн зээл авч үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна. Тус зээлээр уран хөрөө болон гар багаж хэрэгсэл худалдан авч ашиг орлогоо нэмэгдүүлсэн байна. Тус зээлдэгч нь орон нутагтаа танигдаж 2 хүнийг ажлын байраар ханган захиалгын дагуу бүтээгдэхүүнээ борлуулж ашиг орлогоо нэмэгдүүлж байна.



Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцсэн зорилтот төсөлд 2019 онд хамрагдсан иргэдээс доорх иргэд үйл ажиллагаа явуулаагүй байна.

1. Төгрөг сумын Б.Ариунчимэг сүү цагаан идээ боловсруулах чиглэлээр 13.0 сая төгрөг.
2. Арвайхээр сумын Ц.Ариунболд сүү цагаан идээний чиглэлээр 15.0 сая төгрөг;
3. Гучин-Ус сумын ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 2 иргэн хамрагдаж 4.0 сая төгрөг тус тус зээл авсан боловч үйл ажиллагаа явуулаагүй байна. Иймд тус 4 иргэнд зээлдүүлсэн нийт 32.0 сая төгрөгийн зээлийг ХЭДС-нд төвлөрүүлж, цаашид үр дүнтэй төсөл хөтөлбөр хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүд нь төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхдээ сум орон нутгийн эдийн засгийн үндэслэл тооцоолол дээр тулгуурлаагүй, тухайн иргэний төсөл хэрэгжүүлэх төлбөрийн чадвар, ямар үйл ажиллагаа явуулах гэж байгаа зэрэг үндэслэлийг судлаагүй, зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалт зохион байгуулаагүйгээс төслийн хэрэгжилт үр дүн муутай, эргэн төлөлтийн хугацаа хэтрэх гол шалтгаан нь болж байна. Тухайлбал:

ХЭДС-аас хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрөөс олгосон зээлийн эргэн төлөлтийн хэтрэлтийн хэмжээ болон зээл эргэн төлөлт хэтрүүлсэн иргэдийн тоо 2019, 2020 оны байдлаар /сая.төгрөг/

№	Төсөл, хөтөлбөрийн төрөл	2019 он /иргэний тоо/	2019 он хэтрэлтийн хэмжээ	2020 он /иргэний тоо/	2020 он хэтрэлтийн хэмжээ
1	Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцсэн зорилтот төсөл	29	74.7	25	8.9



2	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	30	35.2	-	-
3	Залуучуудын гарааны бизнесийн төсөл	20	79.8		
4	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	133	165.3	162	58.9
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	22	14.2	27	3.2
6	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	14	14.9	10	3.0
	Нийт	248	384.1	224	74.0

Дээрх хүснэгтээс харахад 2019-2020 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдээс зээл авсан нийт 472 иргэний 458.1 сая төгрөгийн зээлийн хугацаа хэтрэлттэй байна.

Хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэг, түүний эргэн төлөлтийн байдлаас үзэхэд гэрээнд заасан хуваарийн дагуу эргэн төлөлт хугацаандаа хийгдээгүй, зарим нь эргэн төлөгдөх эсэх нь эргэлзээтэй байгаа нь ажлын байрны дэмжлэг гэхээсээ илүүтэй халамжийн шинж чанартай болсон байдал ажиглагдаж байна.

Сумдын хөдөлмөр хариуцсан мэргэжилтнүүд ХЭДС-ийн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, эргэн төлөлтөд хяналт тавиагүй, төслийн талаарх сургалт сурталчилгаанд төдийлөн ач холбогдол өгч ажиллахгүй байна.

2019, 2020 онуудын төлөвлөгөө гүйцэтгэл хөтөлбөр, арга хэмжээгээр /сая.төгрөг/

Хүснэгт-9

Хөтөлбөр арга хэмжээний нэр	2019 он				2020 он			
	Хүн	Төлөв	Хүн	Гүйц	Хүн	Төлөв	Хүн	Гүйц
Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх /	84	420.0	147	420.0	120	598.0	222	458.0
Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	210	6.3	240	6.28	125	3.8	159	3.8
Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	0	21.6	21	11.7	0	23.0	21	10.6
Ажил олгогчид олгох дэмжлэг	10	38.4	12	38.3	2	9.1	1	4.1
Нийтийг хамарсан ажил	634	177.6	940	163.5	411	115.0	772	115.0
Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээ	37	70.0	50	20.4	14	25.6	26	24.1
Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах	75	37.5	120	32.9	58	29.0	125	29.0
Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	1050	771.4	1530	693.2	730.0	803.5	1326	644.6

Дээрх хүснэгтээс харахад 2019-2020 онуудад Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт нийт 1780 хүнийг хамруулж 1,574.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс 2856 иргэн хамруулж 1,337.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь төсөл хөтөлбөрт хамрагдахаар хүсэлтээ ирүүлсэн иргэдийн хүссэн санхүүжилтийг үндэслэлгүйгээр бууруулан олгодог байдал нийтлэг байгаагаас шалтгаалж тухайн жилд батлагдсан төсвийг аль болох олон хүнд хүртээж хамруулах гэсэн бодлого мэт харагдаж байгаа боловч эргээд төслийг үр дүнгүй болгох, хэрэгжихгүй байх шалтгаан нөхцөлийг бүрдүүлж байна.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг аудитын тулгалтаар цар тахлын хорио цээртэй холбоотой Арвайхээр сумын 23 иргэний үйл ажиллагаатай танилцахад тус иргэд нь зээлийг зориулалтын дагуу зарцуулсан боловч цар тахалтай холбоотой үйл ажиллагаа нь доголдож зээлийн эргэн төлөлтийн хугацаагаа хэтрүүлж байна.



Сүмдын хувьд:

Сумууд нийтийг хамарсан ажлаар 2019 онд мод тарих, хог цэвэрлэгээ, зам даваа засах ажил, 2020 онд оготно устгал, хог цэвэрлэгээ, сэг зэм устгалын ажлууд хийгдсэн байна.

Сум болгон сумын хогийн цэг цэгцлэх ажилд нийтийг хамарсан ажлын санхүүжилтээ зарцуулж байгаа нь үр дүн муутай ажил байна.

Сумдад олгосон төсөл хөтөлбөрүүдээс харахад ихэвчлэн 1.0-2.0 сая төгрөгийн хооронд олгосон зээл нь үйл ажиллагаа явуулахад үр дүн муутай, сумдад харилцан адилгүй төсөл хэрэгжсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүжилтийн эх үүсвэр дутмаг, түүний дотор дэмжлэг хүссэн хүмүүст олгож буй хөрөнгийн дүн бага байгаа нь ажлын байрыг нэмэгдүүлэх хөшүүрэг болж төдийлөн чадахгүй байна.

Аймгийн статистик мэдээнээс харахад сүүлийн 2 жилийн байдлаар ажилгүйчүүдийн тоо 2019 онд 1165 хүн, 2020 онд 1278 хүн, ажил идэвхтэй хайж байгаа иргэний тоо 2019 онд 1167 хүн 2020 онд 1278 хүн, ажилгүйдлийн түвшин 6.2-6.4 хувьтай гэсэн статистик бүртгэл гарсан нь жил ирэх тусам ажилгүй иргэдийн тоо нэмэгдэж ХЭДС-ийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн гарахгүй байна.

2.3. Төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хүрээнд 2019-2020 онуудад хоёр хөтөлбөрийн хүрээнд 2 тендер зарлаж зохион байгуулсан байна. Тендерийн болон холбогдох баримт бичигтэй танилцаж холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулж шалгаруулсан эсэх, баримт бичгийн бүрдэл бүрэн эсэхийг анхан шатны баримттай тулган шалгалаа. Үүнд:

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2019 онд бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд үр нийлүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулалтад тендер шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар үнийн санал авахаар цахим тендерийг 5 гишүүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороо байгуулж зохион байгуулсан байна. Үнэлгээний хорооны гишүүд бүгд худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдаж АЗ гэрчилгээтэй. Мөн тендерийн урилга, баримт бичгийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны tender.gov.mn, ovorkhangai.hudulmur-halamj.gov.mn сайтуудад мэдээллээ байршуулсан байна. Тендерийн баримтаас үзэхэд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл, үнэлгээний хороо байгуулах тухай ХХҮГ-ын даргын А/07 тоот тушаал үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, Тендерийн нээлтийн тэмдэглэл зэрэг баримт бичгийн бүрдэл бүрэн байна. Тус тендерийг заасан газар, цаг хугацаандаа нээсэн боловч тендерийн материал буюу үнийн санал ирүүлсэн нэг ч ААНБ байхгүй тул тендерийг хүчингүйд тооцож хуулийн дагуу техникийн тодорхойлолт хангасан Хайрхан түнш ХХК-тай үр нийлүүлэх ажлыг 17.5 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр шууд гэрээ байгуулсан байна.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2020 онд тоног төхөөрөмж нийлүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулалтад тендерийн шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар үнийн санал авахаар цахимаар тендер зарлагдаж “Арвайхээр хотын нийтийн тээвэр, гэрэлтүүлэг” ОНӨААТҮГазартай 16.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ байгуулсан байна. Тус тендерийн баримт бичигтэй танилцахад үнэлгээний хороо байгуулсан тушаал байхгүй, үнэлгээний хорооны гишүүдийн АЗ гэрчилгээ байхгүй, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл байхгүй, шалгарсан хуулийн этгээд 2020 онд байгуулагдсан учир ажлын туршлагагүй, өмнөх оны санхүүгийн тайлан байхгүй,



татварын байгууллагын тодорхойлолт байхгүй, нийгмийн даатгалын тодорхойлолт нь албан бус зэрэг зөрчилтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 “Энэ хуулийн 27.3-т зааснаас бусад тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж захиалагч уг тендерээс татгалзана.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төсөл хөтөлбөрийг сонгон шалгаруулалт явуулахдаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийг зөрчсөн байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн дарга А.Ишдорж танаа:

- Салбар зөвлөлийн хуралдааныг улирал тутам хуралдуулж, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж ажиллах.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээл олголт болон эргэн төлөлтийн байдалд хяналт тавьж ажиллан, төсөл, хөтөлбөрийн үр дүнг хурлаар хэлэлцүүлж байх.

БҮЛЭГ-3

***Сангийн үйл ажиллагаанд тавих хяналт
хангалтгүй, хяналтыг хэрэгжүүлж
ажиллахгүй байна.***

3.1. Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавьсан дотоод хяналт хангалтгүй байна.⁴

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх дотоод болон хөндлөнгийн хяналт дараах заалтуудаар тус тус зохицуулагдаж ирсэн. Үүнд:

- ✚ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.9.2. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих;”, 32 дугаар зүйлийн 32.2. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хөндлөнгийн байгууллагаар жил бүр хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэнэ.”,
- ✚ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/83 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж”- ийн 1.2 “Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл болон сум, дүүрэг /хорооны Засаг дарга, иргэдийн төлөөллийн байгууллага байнгын хяналт тавина.”, 1.4 “Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн хяналт-үнэлгээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар жилд 2 удаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам жилд 1 удаа хийнэ.”,

⁴ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 32.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд дараах эрх бүхий байгууллага, албан тушаалтан хяналт тавина:

32.1.1.Улсын Их Хурал, Засгийн газар, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд;

32.1.2.мэргэжлийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу мэргэжлийн хяналтын байгууллага.

32.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хөндлөнгийн байгууллагаар жил бүр хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэнэ.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.1, 28.2 дахь заалтуудыг үндэслэн аймгийн Засаг даргын 2017 оны 04-р сарын 26-ны өдрийн А/189 тоот захирамжаар хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийг шинэчлэн баталж зөвлөлийн 2019 оны 01 тоот тогтоолоор хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн ажлын төлөвлөгөөг батлагдсан боловч хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдийн явц байдалд хяналт, үнэлгээ хийж дүгнэлт гаргах талаар төлөвлөгөөнд тусгагдаагүй, хурлын тэмдэглэлд хяналтын талаар мэдээлэл байхгүй байна.

Мөн Засгийн газрын 2011 оны 311 дугаар тогтоолын дагуу байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам баталж хэрэгжүүлээгүй, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцад хяналт, шалгалт хийж үр дүнг тооцоогүй байна.

ХХҮГ-ын Захиргаа, хяналтын хэлтсийн 2019, 2020 онд хийсэн хяналт, шинжилгээ үнэлгээний тайлангаас харахад үр дүнд чиглэсэн хяналт, шинжилгээ үнэлгээ хийгээгүй, хяналт, шинжилгээ үнэлгээний тайланг харахад байгууллагын үйл ажиллагааны тайланг хуулбарлан бичсэн, хөтөлбөрүүдэд дотоод хяналт хийгдээгүй, санхүүгийн дэмжлэг авсан иргэд гэрээнд заасан төслийн хэрэгжилтийн тайлан мэдээг ирүүлдэггүй, сургалтын чанар, үр дүнд дотоод хяналт хийгдсэн эсэх нь тодорхойгүй, хяналт хийснээр ямар арга хэмжээ авч төсөл хөтөлбөрийн үр дүнг яаж сайжруулсан нь баримтаар нотлогдохгүй байна.

Аймгийн ХХҮГ-ын ажлын хэсэг 2020 оны 11 сарын 02-нд Хархорин, Хужирт сумдад ажиллаж төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үйл ажиллагаатай танилцсанаас өөр хяналт тавиагүй байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл болон сум, дүүрэг хорооны Засаг дарга, иргэдийн төлөөллийн байгууллага байнгын хяналт тавина гэж заажээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журамд заасны дагуу 2019-2020 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд мэргэшсэн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөлд танилцуулаагүй байна.

3.2.Төсөл хөтөлбөрүүдийн тайлан мэдээ нь зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д зааснаар “улирлын тайланг дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад дараа улирлын эхний сарын 5-ны өдрийн дотор, аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад” гаргаж өгнө гэж заасан боловч хөдөлмөр хариуцсан мэргэжилтнүүд гаргасан тайлан мэдээ байхгүй байна.

Жилийн эцсийн байгууллагын гүйцэтгэлийн тайлан дээрх тоо баримт мэдээнүүд нь санхүүгийн жилийн эцсийн тайлан мэдээтэй зөрүүтэй, төсөл хөтөлбөрүүдийн талаар хүрсэн үр дүн тодорхой бичигдээгүй, хяналт тавьж, эргэн төлөлтийн талаар тайлагнаагүй байна.

Аудитаар талбар дээр очиж ажиллахад Арвайхээр, Сант, Баянгол, Төгрөг, Гучин-Ус, Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Хайрхандулаан сумдын мэргэжилтнүүд мэдээ тайлан гаргасан судалгаа болон хийсэн ажлын тайлан байхгүй, зээлдэгч нарийн зээлийн гэрээ болон эргэн төлөлтийн хуваарь байхгүйгээс зээлийн эргэн төлөлтийн араас хөөцөлдөөгүй, тодорхой ажил хийгдээгүй байна.

Цахим мэдээллийн сангийн бүртгэл, ашиглалт хангалтгүй байна.



Ажлын шинэ байрны бүртгэлийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн ажлын байрны бүртгэл хариуцсан мэргэжилтнүүд Ажил олгогч байгууллагууд болон аж ахуйн нэгжтэй холбогдон хамтран бүртгэх ажлыг хийж гүйцэтгэх ёстой боловч тухайн нутаг дэвсгэр дээрх шинээр байгуулагдсан салбар нэгжүүд буюу шинээр бий болж байгаа ажлын байрыг бүртгэх мэдээллийг LMIS программаар бүртгэх үйл ажиллагаа доголдолтой байна.

2019-2020 онуудын байгууллагын нэгжийн гүйцэтгэлийн тайлангаар нийт 3956 иргэн шинээр ажлын байр бий болгож LMIS программд бүртгэсэн гэж тайлагнасан боловч Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системд нийт 2567 иргэн бүртгэлтэй байгаа ба мэдээ, тайлан зөрүүтэй байна. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн LMIS программын үйл ажиллагааны ажиллах горим нь доголдолтой, тайлан мэдээ авахад алдаа гарах зэргээс мэдээллийн сан бүрдүүлж чадахгүй байна. Дээрх байдлаас шалтгаалж Сангийн мэдээллийн тоон үзүүлэлтийг аймаг, сумын хэмжээнд нэгтгэж тайлагнах үйл ажиллагаа доголдсоноос улсын хэмжээний дүн мэдээг үнэн зөв гаргах боломжгүй болох эрсдэлтэй байна.

Байгууллага, нэгж, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон биелэлтийн талаар:

Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын стратегийн төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө, нэгжийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэг бичиг баримтын хоорондын уялдаа хангалтгүй байна. Байгууллагын төлөвлөгөөнд үндэслэл болгосон заалт нь нэгжийн төлөвлөгөөнд дахин хуулбарлагдан бичигдсэн мөн төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тодорхой заалтад мөн хуулбарлан бичигдсэн гэх мэтээр шат дараалсан хуулбарууд баримт бичгүүдээс харагдаж байна.

ТАХ-ийн 2019, 2020 оны үр дүнгийн гэрээнүүдэд хийсэн нарийвчилсан шинжилгээний үр дүнгээс харахад шалгуур үзүүлэлт бодитой бус, үр дүнг хэмжих боломжгүй хэт ерөнхий, хийх ажилтайгаа уялдаатай боловсрогдож чадаагүй дутагдлууд нийтлэг байна.

Төлөвлөгөө боловсруулахад гаргасан энэ алдаанаас шалтгаалан гүйцэтгэлд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хүндрэлтэй байдаг. Цаашид бодлогын шийдвэр гаргах, төлөвлөх, төсөвлөх үйл явцын уялдааг хангах тал дээр анхаарах шаардлагатай байна. Ялангуяа чанарын шалгуур үзүүлэлт, шалгуур үзүүлэлтүүдийн хүрэх түвшинг тодорхойлоход онцгой анхаарах шаардлагатай байна.

3.3. Сангийн үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналт үр дүнгээ өгөөгүй байна.

Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхим 2020 оны 6 дугаар сард ХХҮГ-т хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017-2019 онд хөнгөлөлттэй зээл санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн дунд хяналт үнэлгээ хийх хамтран ажиллах тухай хүсэлт ирүүлсний дагуу 07 дугаар сарын 16-нд хамтран ажиллах гэрээ байгуулж урьдчилгаа 3.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч тухайн хяналт үнэлгээний тайлан гараагүй гэрээний хугацаа сунгасан байна.

Аймгийн МХГ-аас 2019 онд ХЭДС-гийн төсөл хөтөлбөрүүдэд удирдамжийн дагуу шалгалт явуулж ХЭДС-аас санхүүгийн дэмжлэгээр эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийг хугацаандаа төлөөгүй, ажил олгогчид олгох урамшууллыг илүү олгосон, нийтийг хамарсан ажлын хөлсийг ахмад настанд олгосон, сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулсан зэрэг 549.0 сая төгрөгийн зөрчил илэрч ХЭДС-нд буцаан төлүүлэх байцаагчийн акт тогтоосон байна. Үүний дагуу шүүхийн шатанд зээлдэгч нарыг шилжүүлсэн байна.



Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020 оны төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийх удирдамж боловсруулсан боловч шалгалтын ажил хийгдээгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга Т.Нарангараг танаа:

- ХЭДС-аас олгосон төсөл хөтөлбөрүүдийн дотоод хяналтыг сайжруулж, эргэн төлөлтийг хугацаанд нь төвлөрүүлэх талаар санаачилга гаргаж ажиллах.
- Хөтөлбөрийн хөрөнгийг ажлын байрыг тогтвортой нэмэгдүүлэхэд чиглүүлж, иргэдэд бодитой дэмжлэг болохуйцаар зохион байгуулах.
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний боловсруулалтын чанар, хандлага, иж бүрдлийг сайжруулж, биелэлтэд төслийн хүрэх үр дүнгийн талаар тодорхой тусгаж байх
- Төсөл, хөтөлбөрт хамрагдсан иргэдэд хувийн хэрэг нээж хэрэгжих хугацаанд хийсэн тайлан, хяналт, шалгалтын тэмдэглэл, үйл ажиллагааны явцыг баримтжуулж үр дүнг тооцож ажиллах.

ДҮГНЭЛТ:

БҮЛЭГ-1 ХЭДС-гийн үйл ажиллагааны орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт хангалтгүй байна.

- 1.1. Сангийн эх үүсвэрийг хууль, тогтоомжтой уялдуулан оновчтой төлөвлөөгүй байна.
- 1.2. Сангийн орлогыг хуулийн дагуу бүрэн бүрдүүлээгүй, төрийн байгууллагуудтай хамтран ажиллаагүй байна.

БҮЛЭГ-2 Аймгийн ХЭДС-гийн зарим хөрөнгө хууль, журмын дагуу зарцуулагдаагүй, төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт тодорхой үр дүнд хүрээгүй, тендэр шалгаруулалт хуулийн дагуу явагдаагүй байна.

- 2.1. Аймгийн ХЭДС-ийн хөрөнгийг хууль, журмын дагуу олгосон боловч зарим хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- 2.2. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа ч зарим хөтөлбөр тодорхой үр дүнд хүрээгүй байна.
- 2.3. Төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

БҮЛЭГ-3 Сангийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй, хяналтыг хэрэгжүүлж ажиллахгүй байна.

- 3.1. Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавьсан дотоод хяналт хангалтгүй байна
- 3.2. Төсөл хөтөлбөрүүдийн тайлан мэдээ нь зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.
- 3.3. Сангийн үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналт үр дүнгээ өгөөгүй байна.



ЗӨВЛӨМЖ:

Аймгийн ИТХ-ын дарга О.Пүрэвдорж, Засаг дарга А.Ишдорж нарт:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, журмын дагуу орон нутгийн төсвөөс аймгийн ХЭДС-д төсвийн орлогын 0.3 хувиас доошгүй хөрөнгийг хуваарилан төвлөрүүлж байх.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн дарга А.Ишдорж танаа:

- Салбар зөвлөлийн хуралдааныг улирал тутам хуралдуулж, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж ажиллах.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээл олголт болон эргэн төлөлтийн байдалд хяналт тавьж ажиллан, төсөл, хөтөлбөрийн үр дүнг хурлаар хэлэлцүүлж байх.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга Т.Нарангараг танаа:

- Хөтөлбөрийн хөрөнгийг ажлын байрыг тогтвортой нэмэгдүүлэхэд чиглүүлж, иргэдэд бодитой дэмжлэг болохуйцаар зохион байгуулах.
- Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийн орлогыг үндэслэлтэй бүрэн төлөвлөж, тухайн байгууллагуудтай хамтарч ажиллах.
- ХЭДС-аас олгосон төсөл хөтөлбөрүүдийн дотоод хяналтыг сайжруулж, эргэн төлөлтийг хугацаанд нь төвлөрүүлэх талаар санаачилга гаргаж ажиллах.
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний боловсруулалтын чанар, хандлага, иж бүрдлийг сайжруулж, биелэлтэд төслийн хүрэх үр дүнгийн талаар тодорхой тусгаж байх
- Төсөл, хөтөлбөрт хамрагдсан иргэдэд хувийн хэрэг нээж хэрэгжих хугацаанд хийсэн тайлан, хяналт, шалгалтын тэмдэглэл, үйл ажиллагааны явцыг баримтжуулж үр дүнг тооцож ажиллаж байх.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

